



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 41653

Хэрлэн сум

“Монгол Улсын хөгжлийн бодлого- Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сургалтад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эдийн засаг хөгжлийн яам, Удирдлагын академиас чиглэл болгон бүх орон нутгийн түвшинд зохион байгуулж буй төрийн албан хаагчдад хөгжлийн бодлого, төлөвлөлт ба байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг уялдуулан төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилготой “Монгол Улсын хөгжлийн бодлого-Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сургалтад 4,310,000 (дөрвөн сая гурван зуун арван мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 12 ний өдрийн
11655 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ ₮	Нийт үнэ ₮
1	Өдрийн хоол	90	22,000	1,980,000
2	Цайны завсарлага	180	7,500	1,350,000
3	Цэвэр ус	100	1800	180,000
4	Танхимын түрээс	8 цаг	100 000	800 000
	Нийт дүн			4,310,000